



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2018 оны 02 дугаар сарын 05

№ 01/07 ДУА-2018/128/СТА-ТЦЗ Мандалговь хот

**Төлбөр барагдуулах тухай**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Татварын хэлтсийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үр дүнгийн гэрээ байгуулаагүй, ажлын цагийн бүртгэлгүй, ажил хөдөлмөр эрхлээгүй, орон тооны бус албан тушаалтанд **2,218,391.00** /Хоёр сая хоёр зуун арван найман мянга гурван зуун ерэн нэгэн/ төгрөгийн цалин бодож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т /Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-т /"анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог/, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, мөн тухайн үед мөрдөгдөж байсан Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2006 оны 06 сарын 25 ны өдрийн 171/111 тоот тушаалын хавсралтын 4.2-т /...Ажлын цагийн тооцоог үндэслэн цалин хөлсийн тооцоог хийх.../, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолын 2.а-д /Бүх шатны төсөв захирагч нарт салбар болон байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зэргээр орон тоо, цалин хөле, урсгал зардлыг бууруулах, батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх эрхийг олгох/, Төсвийн тухай хуулийн 16.5.3-т /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, 41.2.3-т /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ заасныг тус тус зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3-д /Бусдад

огох тольбор тооцоог зөрүүтэй тооцоолж өгдөгсөн гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ**  
**НЬ:**

1. **2,218,391.00** /Хоёр сая хоёр зуун арван найман мянга гурван зуун ерэн нэгэн/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Татварын хэлтсийн төсвийн шууд захирагч М.Туяацэцэг, нягтлан бодогч Н.Долгорсүрэн нарт хариуцуулав.

**ТОГТООСОН:**  
АУДИТОР  Ж.УГТАХБАЯР  
4817144213  
ЗЮА0039 9033475

**АКТЫГ**

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.ТУЯАЦЭЦЭГ  
НЯГТЛАН БОДОГЧ  Н.ДОЛГОРСҮРЭН  
ТУ30915 9034218 4817153591

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.